

5

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГО, АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

П.Баяржавхлан

I

Зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд бие даасан аливаа аж ахуйн нэгж, төсвийн, ашгийн, ашгийн бус аль ч байгууллага орлого олж, хөрөнгө оруулж хөрөнгийн үнэ цэнийг өсгөж захиран зарцуулж байдаг.

Аж ахуйн нэгж өөрийнхөө зах зээлийн байдлыг тодорхойлж, санхүүгийн байдлыг харуулах эдийн засгийн үзүүлэлтээ нарийн судалж шинжлэх шаардлага байнга гардаг. Эдгээр нь санхүүгийн менежер, санхүүгийн байгууллагын оролцоотойгоор хэрэгждэг бөгөөд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, хянахад төдийгүй түүний түншүүд болох банк гэрээт аж ахуйн нэгж, хувь нийлүүлэгчдэд чухал хэрэгтэй.

Санхүүгийн шинжилгээний тусламжтайгаар өөрийн компанийн үйл ажиллагааг ижил салбарын үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудтай зэрэгцүүлэх боломж бий болдог.

Орлого, ашгийн иж бүрэн шинжилгээг хийхдээ эхлээд түүний гол бүрдэл хэсгүүдээр нь тухайлбал борлуулалтын ашгийг онцлон шинжлэх хэрэгтэй.

Чухамхүү үндсэн бүтээгдэхүүний борлуулалтын ашгийн хэмжээ, хувийн жингээр тухайн байгууллагын төрөлжилтийн түвшин илэрхийлэгдэнэ. Дараа нь таваарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээс олох ашгийн өөрчлөлтийн томруулсан хүчин зүйлсийг тухайлбал таваарын бүтээгдэхүүний төгрөг тутамд ногдох зардлын шинжилгээг хийх учиртай.

Үүний дараа борлуулалтын хэмжээ ба бүтцийн өөрчлөлт, борлуулсан бүтээгдэхүүний үнийн түвшин, мөн түүнчлэн худалдан авсан түүхий эд материал, түлш эрчим хүч, бусад ашигт яаж нөлөөлсөнийг шинжилнэ. Тэр ч байтугай аж ахуй санхүүгийн үйл ажиллагааны сахилга зөрчсөнөөс ашигт яаж өөрчлөгдсөнийг судалж байх шаардлагатай. Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл, бусад борлуулалт, борлуулалтын үйл ажиллагааны орлого гэж нэрлэгддэг зүйлсүүдийг ч нарийвлан судалваас нилээд зүйлсийг танин мэдэж болно.

Ашгийн туйлын хэмжээ нь тухайн байгууллага хэрхэн ажиллаж байж ашгийг олсныг тодорхой илтгэж чаддаггүй бол ашгийн харьцангуй хэмжигдэхүүн болсон ашигт ажиллагаа нь ямар бааз дээр суурилж, хэр зэрэг эрчимтэй ажиллаж уг ашгийг олсныг харуулдагаараа чухал үзүүлэлт юм. Иймээс энэ хоёр үзүүлэлт нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлнэ.

Бизнесийн эцсийн зорилго нь ашиг олох явдал бөгөөд оруулсан хөрөнгийг илүү үр бүтээлтэй ашиглаж орлогоороо зардлаа нөхөөд ашигтай ажилласан нөхцөлд үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой болдог.

Ашигт ажиллагааны шинжилгээг дараах үзүүлэлтүүдийн дагуу хийж, өнгөрсөн он болон төлөвлөгөөтэй зэрэгцүүлэн дүгнэлт өгнө.

Хүснэгт 1

Үзүүлэлтүүд	Томъёолол	Тэмдэглээ
Борлуулалтын ашигт ажиллагаа	$B_{AA} = \frac{Y/A_{цo}}{B_o}$	Y/A _{цo} - Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого B _o - Борлуулалтын орлого
Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	$\Theta B_{AA} = \frac{Y/A_{цo}}{B_{бe}}$	Y/A _{цo} - Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого B _{бe} - Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
Хөрөнгийн ашигт ажиллагаа	$X_{AA} = \frac{C_A}{B_{цд}}$	C _A - Цэвэр ашиг B _{цд} - Балансын цэвэр дүн
Өөрийн капиталын ашигт ажиллагаа	$\Theta K_{AA} = \frac{C_A}{\Theta_k}$	C _A - Цэвэр ашиг Θ _k - Өөрийн капитал

Шинжилгээний практикт үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны үзүүлэлтийг тооцдог. Энэ нь борлуулалтын ашгийг уг бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөгт харьцуулсан харьцаа юм.

Ашиг нь өөрийн өртгийн адил үнэтэй бас холбоотой учраас бүтээгдэхүүний ашигт ажиллагааг мөн түүнчлэн ашгийн чөлөөт болон зохицуулсан үнээр борлуулах өртөгт харьцуулан тодорхойлж болно. Эдгээр үзүүлэлтүүд нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд нийт бүтээгдэхүүний болон түүний төрөл тус бүрийн үйлдвэрлэл, борлуулалтын шуурхай зардлын өөрчлөлтийг илтгэн харуулна.

Ашигт ажиллагааны аль ч үзүүлэлтийн хүчин зүйл нь эдийн засгийн нэмэгдэл үзэгдэл, үйл явцаас хамаарна. Эдгээрийн заримаас нь нэрлэвэл:

- Мөнгө санхүүгийн хүрээн дэхь хямралыг богино хугацаанд хохирол багатайгаар даван туулж, санхүүгийн зах зээлийг жинхэнэ утгаар төлөвшүүлэх үндсэн дээр үйлдвэрлэл санхүүгийн удирдлагыг сайжруулах
- Төлбөр тооцооны механизмыг сайжруулах замаар нөөцийн капиталын үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц үзүүлэх
- Эргэлтийн хөрөнгийг индексжүүлж түүний бүрдүүлэх эх үүсвэрийг маш тодорхой болгох
- Аж ахуйн нэгж байгууллагын хооронд урт хугацааны тогтвортой хэлхээ холбоо тогтоож, түүнийг санхүү зээл, төлбөр тооцооны механизмаар баталгаажуулж, хангамж борлуулалтын үйл ажиллагаанаас өөрчлөн сайжруулах зэрэг болно.

Үйлдвэрлэл борлуулалтыг өсгөх, шинжлэх ухаан техникийн ололтын үндсэн дээр бүтээмжийг тасралтгүй дээшлүүлэх, өөрийн өртгийг хямдруулах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх явдал бол ашгийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйлс юм.

Мөнгөн хуримтлалын гол хэлбэр болсон ашиг нь зохих үнээр хийсэн борлуулалтын орлогоос бүрэн өөрийн өртгийг судалж үнэ яаж нөлөөлснийг шинжилгээний уламжлалт аргаар судалж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай. Зардлыг хямдруулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийн асуудлыг товчхон авч үзэх нь зүйтэй гэж үздэг.

II

Аж ахуйн нэгжийн орлого, ашгийн байдлыг шинжлэхэд хэд хэдэн аргыг ашиглаж болох бөгөөд жишээ нь:

- Энгийн динамик
- Автокорреляци
- Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний арга зэргээр аж ахуйн орлого, ашгийн байдлыг шинжлэн дүгнэж прогнозын тооцоо хийнэ. Эдгээр аргуудыг нарийвчлан авч үзэх нь тухайн аж ахуйн нэгжийн орлого, ашгийн байдал, тэдгээрийн хүчин зүйлийн нөлөөлөл тодорхой болж, цаашдын үйл ажиллагаандаа авах арга хэмжээ, чиглэл хэтийн төлөвийг тодорхойлоход дөхөм болно. Тиймээс орлого ашгийн шинжилгээ болон төлөвлөлтийн асуудал хоорондоо нягт холбоотой.

Дээрхи бүх арга аргачлалыг ашиглан "МЦХ" ХК-ийн орлого ашгийн байдалд шинжилгээ хийсэн болно.

Балансын үзүүлэлтүүдийн өсөлт, бууралтыг өмнөх онтой харьцуулж

/ төг-р, хувиар / гаргасан тооцоо

		Хүснэгт						
Санхүүгийн үзүүлэлтүүд		1997	1998	1999	2000	2001	2002	2003
А. Нийт хөрөнгө	Мян. төг	3337803.0	2723679.6	2514690.3	4443279.2	2844241.3	3022906.3	2123302.7
	%-иар	53.86	28.56	20.51	30.07	14.80	13.70	84.63
1. Эргэлтийн хөрөнгө	Мян. төг	1947553.2	-252303.8	1910564.7	2818721.8	1175110.9	-	18547
	%-иар	52.64	-4.47	35.41	38.58	11.60	-16.04	5.4
2. Эргэлтийн бус	Мян. төг	1390249.8	2975920.4	604188.6	1624557.4	1669130.4	4835425.7	1937827.4
	%-иар	55.66	76.54	8.80	21.75	18.36	44.93	12.42
А. Биет хөрөнгө	Мян. Төг	532171.6	2864651.2	427973.5	1615212.2	1674699.8	3970147.	28016
	%-иар	22.35	98.33	7.40	26.03	21.41	41.81	20.81
Б. Биет бус	Мян. Төг	858078.2	111269.2	176215.1	9345.2	-5569.4	865278.1	-
	%-иар	736.34	11.42	16.23	0.74	-0.43	68.35	-40.53
А. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	Мян. Төг	3337803.0	2723679.6	2514689.3	4443280.2	2844241.3	3022906.3	2123302.7
	%-иар	53.86	28.56	20.51	30.07	14.80	13.70	8.46
1. Өр төлбөр	Мян. Төг	318371.5	712649.4	172091.7	1926993.8	365413.9	1236169	479927.5
	%-иар	15.83	30.59	-5.65	67.14	7.61	23.94	7.50
А. Богино хугацаат өр	Мян. Төг	-490136.3	982215.7	172350.8	2087127.2	-647120.5	517011.9	1603593.6
	%-иар	-24.37	64.58	6.88	78.01	-13.58	12.56	34.61
Б. Урт хугацаат өр	Мян. Төг	808507.8	-269566.3	-344442.5	-160133.4	1012534.4	719157.2	-
	%-иар	11236	57.2	-	-	-	-	-
2. Эзэмшигчдийн өмч	Мян. төг	3019431.5	2011030.2	2686781	2516286.4	2478827.5	1786737.	16433
	%-иар	100	-33.34	-63.91	-82.33	2.94	68.69	-63.62
А. Өмч	Мян. төг	1	1	1	1	1	1	75.3
	%-иар	72.12	27.90	29.15	21.13	17.19	10.57	8.79
Б. хувьцаа	Мян. төг	2449171.5	-	-	-	-	-	137856.1
	%-иар	100.0	-	-	-	-	-	5.63
В. Хуримтлагдсан ашиг /алд/	Мян. төг	-	2341472.6	2341472.1	-	-	-	-
Тайлангийн	%-иар	94.44	-1698.5	-	-	-	-	-

үсийн ашиг	Мян. Төг	3009431.5	1903331.3	2686781.0	2516286.4	2478827.5	1786737.1
	%-иар	176.88	40.27	40.52	27.01	20.94	12.48
	Мян.төг	2119616.9	-683517.5	867039.9	958673.0	-	889502.7
	%-иар	140.30	18.83	29.42	25.14	-14.39	-21.77

"МЦХ" ХК-ий 1996-2003 оны санхүүгийн тайлан

Зэрэгцүүлэлтээс харахад 1996 онд 6197,2 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй байсан бол 2003 онд 27207.1 сая төгрөг болж 21009.9 сая төгрөгөөр буюу бараг 3,4 дахин өссөн байна. Үүний дотор 1996 онтой харьцуулахад эргэлтийн хөрөнгө 5972.6 сая төгрөгөөр буюу 161.4%-иар, эргэлтийн бус хөрөнгө 158037.3 сая төгрөгөөр буюу 6,0 дахин өссөн нь техник, технологийн шинэчлэл хийгдсэнтэй холбоотой байна. Богино хугацаат өр төлбөр 2003 онд 3,1 дахин буюу 4225.0 сая төгрөгөөр өссөн буюу 8 жилийн туршид тогтворгүй байдлаар их хэмжээгээр өсөж, буурч байсан нь харагдаж байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж хөрөнгө оруулалтаар банкнаас урт хугацаат зээл авч дараагийн жилүүдэд төлж байсан нь урт хугацаат өр төлбөрийн хэмжээ их хэмжээгээр хэлбэлзсэн харагдаж байна.

Хүснэгт 3: Орлого, ашгийн шинжилгээ

Үзүүлэлтүүд	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Цэвэр борлуулалт	10453.1	17435.6	18975.4	24016.5	28672.8	30089.5	29776.2	31402.6
Нийт борлуулалт	10453.1	117519.2	19496.1	24693.2	29644.6	30559.4	29864.0	31541.1
Борлуулалтын хөнгөлөлт	-	83.6	520.6	676.6	971.7	-469.9	87.8	140.0
Үйл ажиллагааны зардал	8069.0	11447.8	13483.4	16811.4	19715.5	21898.3	23448.6	27708.4
Үйл ажиллагааны ашиг	2384.1	5987.8	5492.0	7205.2	8957.3	8191.1	6327.6	3694.1
Үйл Ажиллагааны бус орлого	743.3	782.9	937.9	827.1	1347.4	405.8	383.9	493.1
У/а бус зарлага	211.4	316.8	497.5	512.6	722.4	767.2	672.6	1191.1
Ердийн ажиллагааны ашиг	2916.0	6454.0	5932.4	7519.7	9582.4	7829.8	6038.9	2995.6
Татвар төлөхийн өмнөх ашиг	2916.0	6454.0	5932.4	7519.7	9582.4	7829.8	6038.9	2995.6
Орлогын татварын зардал	1405.3	2823.6	2985.6	3705.8	4809.9	3744.1	2842.8	1525.8
Тайлант үеийн цэвэр ашиг	1510.7	3630.3	2946.8	3813.8	4772.5	4085.6	3196.1	1469.8

"МЦХ" ХК-ний санхүүгийн тайлангаас иш татав.

Борлуулалтын орлого 1996 онд 10453.1 сая төгрөг байсан бол сүүлийн жилүүдэд орлогын хэмжээ жил дараалан нэмэгдсээр 2003 онд 31402.6 сая төгрөг болж 3.0 дахин өссөн байхад үйл ажиллагааны бус орлого 2003 онд 1996 оны түвшингээс 50.6 хувиар буурсан боловч нийт орлого 1996 оныхоос 2.57-иар өссөн байна. Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал буюу ашигт ажиллагааны түвшин 2000 онд 29.92 хувь байсан бол 2001 онд 24.1 хувь, 2002 онд 18.8 хувь, 2003 онд 8.84 хувь болон буурсан байна.

Ашигт ажиллагааны түвшин нэгэнт хүрсэн 2000 оныхоос (0.2992 - 0.0884=0.2108) 21.08 хувиар буурсанаар (0.2992*33898.9-2995.6=7146.9) 7146.9 төгрөгийн ашиг олох боломж алджээ. Ашигт ажиллагааны түвшинг 2002 оны хэмжээнд (0.1877) байсан бол 370.5 сая төгрөгийн ашиг олох боломж алдсан байна. Бизнесийн үйл ажиллагааны эцсийн зорилго ашиг олох явдал байдаг. Иймээс ашигт ажиллагааны түвшин, өртөг зардал, орлогын хэмжээнд нарийвчилсан судалгаа хийж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарвал зохих хүчин зүйлүүдийн нөлөөллийг илрүүлэх нь шинжилгээний гол зорилго болно. Иймд борлуулалтын орлого, ашигт ажиллагааны харилцан харилцан хамаарлыг муруй шугамын регрессийн шинжилгээний аргыг гиперболлоор тэгшитгэх аргаар тооцоог хийвэл:

	Орлог о (X)	Ашигт ажиллагаа (y)	$\frac{1}{X}$	$\frac{1}{X^2}$	$\frac{Y}{X}$	$\frac{Y}{X}$
1996	13,1924	0.221	0.00758012	0.00574582	0.0167521	0.233
1997	20,2155	0.3192	0.00494669	0.00244698	0.0157898	0.232
1998	21,9113	0.2707	0.00456385	0.00208287	0.0123543	0.230
1999	26,8426	0.2801	0.03725421	0.00138787	0.0104349	0.247
2000	32,0202	0.2992	0.03123028	0.00009753	0.0093441	0.244
2001	32,4963	0.2409	0.00003077	0.00094696	0.0074131	0.230
2002	32,1621	0.1877	0.031092497	0.00096674	0.0058360	0.244
2003	33,8989	0.0884	0.029499482	0.00087022	0.0026077	0.244
Σ	-	1.9072	0.149098417	0.01538499	0.0809195	1.9072

Ашигт ажиллагаа орлогын түвшингийн хамаарал сүүлийн жилүүдэд буурсан харагдаж байна. Судалгаанаас харахад ашигт ажиллагааны түвшин, борлуулалтын орлогын түвшний хамаарал 0.2-0.24 тэй байгаа нь хамаарал муу байгааг харуулж байна.

Үйл ажиллагааны зардал, ашигт ажиллагааны хамаарлыг 2-р эрэмбийн параболоор тэгшитгэх аргаар тооцоо хийж үзвэл:

Хүснэгт 5: Ашигт ажиллагааны шинжилгээ

Он	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны ашиг	X ²	Y ²	XY
1996	80690033.9	2384107.2	6510881570783150.0	5683967141091.8	192373690789234.0
1997	11447835.7	5987769.5	131052942214194.0	358533835851.30	68547001445471.1
1998	13483425.6	5492019.9	181802765910735.0	30162282581996.8	74051241715369.4
1999	16811377.0	7205179	282622396636129.0	51914604422041.8	121128980521483.0
2000	19715536.0	8957318	388702359767296.0	80233545753124.0	176598325492448.0
2001	21898375.0	8191127	479538827640625.0	67094561530129.0	179372370718625.0
2002	23448610.8	6327587.7	549837348449877.0	40038366101191.0	148373141280167.0
2003	27708442.1	3694179.8	767757763609052.0	13646964394728.0	102359967095290.0
Дүн		0.6830299	93470190119528000.0	347885799254088.0	2462026718737680.0

$$r = \frac{n \sum xy - (\sum x)(\sum y)}{\sqrt{n \sum x^2 - (\sum x)^2} \cdot \sqrt{n \sum y^2 - (\sum y)^2}}$$

Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа борлуулалтын орлогоос хамаарах хамаарлын түвшин 0.244 байхад үндсэн үйл ажиллагааны зардлаас хамаарлын түвшин 0.683, энэ хоёр хамаарлын коэффициентийн нийлбэр 0.927, бусад хүчин зүйлийн хамаарлын түвшин 0.073 байна.

Хүснэгт 6

Үзүүлэлтүүд	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
Борлуулалтын ашигт ажиллагаа	0.180	0.296	0.250	0.268	0.279	0.252	0.196	0.108
Өртгөөрх борлуулалтын ашигт ажиллагаа	0.295	0.523	0.407	0.428	0.454	0.374	0.269	0.133
Хөрөнгийн ашигт ажиллагаа	0.243	0.380	0.240	0.258	0.248	0.185	0.127	0.054
Өөрийн капиталын ашигт ажиллагаа	0.360	0.503	0.319	0.320	0.330	0.241	0.171	0.072

“МЦХ” ХК-ний санхүүгийн тайлангаас иш татав /1996-2003/

1996 онд борлуулалтын ашигт ажиллагааны түвшин 0.18 байсан бол, 2000 он хүртэл аажмаар нэмэгдсээр 0.279-д хүрсэн бол, 2001, 2002, 2003 онуудад жил дараалан буурсаар 2003 оны эцэст 0.108 болж өсчээ.

Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагааны түвшин мөн 2000 оноос хойш жил дараалан буурч 0.133 болсон байна.

“МЦХ” ХК-д хийгдсэн технологийн шинэчлэл нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, өртгийг бууруулахад нөлөөлсөн боловч, бүтээмжийн өндөр өсөлт нь өртгийг хямдруулахад төдийлөн нөлөөлж чадаагүй бөгөөд тогтмол зардлыг нэмэгдүүлж улмаар элэгдлийн болон зээлийн хүүгийн зардлын дарамтыг бий болгосон байна.

Нөгөө талаас үйлдвэрлэлийн уян хатан байдал алдагдаж бизнесийн хөрвөх чадвар буурахад нөлөөлжээ. Иймд өртгийн шинжилгээг зардлын төрөл бүрээр нарийвчлан шинжлэх шаардлагатай байна.

“МЦХ” ХК-ний нийт зардлын 60.63 хувийг тогтмол зардал, 39.36 хувийг хувьсах зардал эзэлж байгаа нь зардлын бүтэц муу байгааг харуулж байна.

2002-2003 оны борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал.

Үзүүлэлт	Хувьсах	Тогтмол	Хүснэгт 7
			Дүн
2002 он	0.10440585	0.175565833	0.27397168
2003 он	0.34732543	0.535035360	0.88236078

Тогтмол зардлын түвшингээс ашигт ажиллагааны түвшин хэрхэн хамаарч байгааг корреляцийн шинжилгээгээр тооцож үзье.

$$r = \frac{n \sum xy - (\sum x)(\sum y)}{\sqrt{n \sum x^2 - (\sum x)^2} \cdot \sqrt{n \sum y^2 - (\sum y)^2}} = 0.9151$$

Хүснэгт 8.

	Тогтмол зардал X	Ашиг Y	xy	x ²	y ²
1998	0.17103256	5492019.9	939314.223	0.29252136	30162282581.9
1999	0.16540232	7205179.0	1191753.322	0.027357927	51914604422.0
2000	0.17245680	8957318.0	1544750.399	0.029741347	80233545753.1
2001	0.16958975	8191127.0	1389131.18	0.02876068	67094561530.1
2002	0.175565813	6327587.7	1110908.186	0.03082336	40038366101.1
2003	0.53503536135	3694179.8	1976516.82	0.28626283	13646964394.7
	1.38908262	39867411.4	8152374.13	0.43219828	283090324782.9

Дээрхи тооцоогоор ашиг тогтмол зардлын хамаарал 0.915 гарсан нь тогтмол зардал цэвэр ашгийн хүч их хамааралтай байгааг харуулж байна. Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлын шинжилгээнээс үзэхэд 2002 онд борлуулалтын орлогын нэг төгрөгт 0.1755 мөнгөний зардал гаргаж байсан бол 2003 онд 0.535 мөнгө болж нэмэгдсэн нь ашиг буурахад нөлөөлсөн байна.

2002 онд борлуулалтын орлогын нэг төгрөг тутамд 0.273 мөнгөний элэгдлийн зардал гарч байсан бол 2003 онд 0.882 мөнгө болж нэмэгдсэн нь ашигт ажиллагаа буурахад нөлөөлжээ. Тогтмол зардлыг дотор нь зардлын нэр төрлөөр нь авч үзэхэд элэгдлийн зардал, бусад зардал / хүүгийн зардал ороод/ нэмэгдсэн зэргээс ашигт ажиллагаа буурахад нөлөөлсөн байна.

Хувьсах зардлын түвшингээс ашигт ажиллагааны түвшин хэрхэн хамаарч байгааг корреляцийн шинжилгээгээр тооцож үзье. Ашигт ажиллагааны түвшин хувьсах зардлаас хамаарлын хүч бага буюу ашигт ажиллагааны түвшин буурахад нөлөөлөөгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 9

Хувьсах Зардал (X)	Ашиг (Y)	xy	x1	y	
1998	0.13354687	5492019.9	733442.0676	0.017834766	30162282582
1999	0.12354542	7205179	890166.8657	0.015263471	51914604422
2000	0.11525452	8957318	1032371.387	0.013283604	80233545753
2001	0.10556425	8191127	864690.1784	0.011143811	67094561530
2002	0.10440585	6327587.7	660637.1723	0.010900582	40038366101
2003	0.34732543	3694179.8	1283082.588	0.120634954	13646964395
Дүн	39867411.4	5464390.258			2.8309E+11

$$r = \frac{n \sum xy - (\sum x)(\sum y)}{\sqrt{n \sum x^2 - (\sum x)^2} \cdot \sqrt{n \sum y^2 - (\sum y)^2}} = -0.787$$

Дүгнэлт санал

Тус компанийн орлого ашгийн сүүлийн 8 жилийн динамик судалгаанаас үзэхэд 2002 он үйл ажиллагааны хувьд хамгийн үр дүнтэй ажилласан, хөрөнгийн харьцаа зүй зохистой хэмжээнд хүрсэн жил байжээ.

Хөрөнгийн болон өөрийн капиталын ашигт ажиллагаа тогтворгүй, 2000 оноос хойш жил дараалан буурч 2003 оны эцэст тус бүр 0.054, 0.072 коэффициенттэй байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны ашиг буурсан, үл хөдлөх хөрөнгийн хэмжээ ихээхэн нэмэгдсэнээс шалтгаалсан байна. 2000 оноос хойш үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шинэ технологи нэвтрүүлсэн боловч, үйлдвэрлэлийн үр ашигт нөлөөлөхүйцээр ашиглаж үр дүнд хүрч чадаагүй байгаатай холбоотой байна.

Цаашид үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, шинэ техник технологийн хүчин чадал ашиглалтыг дээшлүүлж, ашигт ажиллагааг хангах талаар нилээд анхаарах шаардлагатай байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг жил дараалан өссөн байхад үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого нэмэгдэх бодит боломж төдийлөн сайн бүрдээгүй байна.